

МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/151

Зуунмод

Газар эзэмшүүлэх дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, "Газрын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2018 оны 182 тогтоолоор баталсан дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлал, 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын баталсан 2019 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 байршилд дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, анхны үнэ, дэнчингийн үнэ, дуудлага худалдаа зохион байгуулах хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг холбогдох хууль, журам төлөвлөлтийн дагуу зохион байгуулахыг Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/ нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 00 393

Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 02-ний өдрийн
А/15/ дугаар захирамжийн хавсралт

2019 ОНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДҮҮДЛАГА ХУДАЛДААНЫ ХУВААРЬ

Д/а	Баг	Байршил	Талбайн солбиол	Газрын хэмжээ /м.кв/	Зориулалт	Эрхийн төрөл	Эрхийн хугацаа	ДХ-ны хэлбэр	Анхны үнэ /мян.төг/	ДХ эхлөн байгуулах хугацаа
1	Номт баг	Хуульчдын хотхоны урд талд	645562.97 5285783.68	1700	Цэцэрлэг	Эзэмших	15	Цахим	8,500.0	4-р сар
2	Номт баг	Дашваанжил газрын орчим	644910.23 5285674.5	1000	ШТС	Эзэмших	15	Танхим	5,000.0	4-р сар
3	Номт баг	28-р байрны урд	646409.31 5285912.45	100	Үйлчилгээ	Эзэмших	15	Танхим	500.0	4-р сар
4	Ланс баг	Ланс уулын урд талд	647507.01 5286368.871	30000	Цанын бааз	Эзэмших	15	Цахим	12,000.0	4-р сар
5	Баруун- Зуунмод баг	Дотуур байрны хойд талд	646667.06 5285637.26	100	Амины орон сууц	Эзэмших	15	Танхим	500.0	4-р сар
6	Баруун- Зуунмод баг	Дотуур байрны хойд талд	646667.06 5285637.26	100	Амины орон сууц	Эзэмших	15	Танхим	500.0	4-р сар
7	Баянхошуу баг	Үйлдвэрийн бүсэд	645396.08 5282998.22	20000	Үйлдвэр	Эзэмших	15	Цахим	64,000.0	4-р сар
8	Номт баг	Зуунмод хотын шинэ төвд	645748.28 5285210.59	1300	Оффис	Эзэмших	15	Цахим	6,500.0	4-р сар
9	Баянхошуу баг	Үйлдвэрийн бүсэд		1000	Үйлдвэр, үйлчилгээ	Эзэмших	15	Цахим	4,000.0	5-р сар
10	Номт баг	Хуульчдын хотхоны урд талд	645789.98 5285614.55	700	Оффис	Эзэмших	15	Танхим	3,500.0	5-р сар
11	Номт баг	8-р байрны урд	645605.59	100	Үйлчилгээ	Эзэмших	15	Танхим	500.0	5-р сар
12	Номт баг	Нефть хангамжийн хашааны урд талд	5283807.31	10000	Үйлдвэр	Эзэмших	15	Цахим	10,000.0	5-р сар

Тослоо хийсэн: ГХБХБГ-ЫН МЭРТЭЖИЛТЭН

Хянасан: ГХБХБГ-ЫН ДАРГА

Б БАТБАЯР

МОТОНБАТ